



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 504-01

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МАТАД СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ДАРГА
Э.ТӨМӨРБААТАР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын сонгуульд оролцох Матад сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Матад сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Матад сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Матад сумын Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Матад сумын Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: /Аймгийн/ Сонгуулийн хороонд
Хавсралт . . хуудастай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР БОЛОРТУУЛ



011020521

Матад сумын Монгол Ардын намын хорооны
2020 оны 06 сарын 11 өдрийн 7 дугаар
тогтоолын 4 хавсралт

ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2117:4
ЖНУА0056 0030391

Монгол Улсын Их хурлаар баталсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр холбогдох хууль тогтоомж, сум орны хөгжлийн хэтийн төлөвийн талаарх иргэдийн санал бодол, мэргэжилтнүүдийн судалгаанд үндэслэн мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

Мөрийн хөтөлбөрийн эрхэм зорилго нь хөдөө аж ахуйд суурилсан уламжлалт мал аж ахуйг дэмжиж, хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтийг хангасан иргэдийн амьдрах аюулгүй таатай орчинг бүрдүүлсэн АЙМАГТАА тэргүүлсэн Жишиг сум болоход оршино.

УРИА: БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

Хэрэгжих хугацаа 2020-2024 он

НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО:

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах талаар

1.1.1 Боловсон хүчний нөөцийг чадавхжуулах сургалт, төрийн байгууллагуудын туршлага солилцох уулзалтууд зохион байгуулж төрийн албан хаагчдыг амьдрах орон байраар хангана.

1.1.2 Төрийн үйл ажиллагааг хөнгөн шуурхай ил тод нээлттэй хүргэх зорилгоор төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргэж төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Орлоготой иргэн- орлоготой өрх

1.2.1 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.2.2 Сум хөгжүүлэх сангийн зээлийн санхүүжилтийг гарааны бизнесээ амжилттай эрхэлж буй үр дүнд хүрэхүйц бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжиж шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.

Эрүүл мэндийн талаар

1.3.1 Иргэдийн эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж бусад эрүүл мэндийн байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлнэ.

1.3.2 Эрүүл шүд, Эрүүл хүүхэд хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхдийн шүдний эмчийг бэлтгэн суманд шүдний кабинетийг байгуулна.

1.3.3 Эрүүл мэндийн төвийг нэн шаардлагатай орчин үеийн тоног, төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

1.3.4 Эрүүл мэндээ сайжруулахад чиглэсэн идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх, нийтийн биеийн тамирын талбай, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

1.3.5 Алслагдсан багийн иргэдэд эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах боломжийг хангаж явуулын эрүүл мэндийн баг тогтмол ажиллуулна.

1.3.6 Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлж орон сууцаар хангахыг бодлогоор дэмжиж ажиллана.

Гадаад харилцааны талаар

1.4.1 Хүн амын тоо ойролцоо, байгаль, цаг уурын ижил төстэй бүс нутагт орших Дорнод болон бусад аймгийн сумд, гадаадын хот, тосгод, суурин газруудтай хамтын ажиллагаа хөгжүүлнэ.

1.4.2 Хөдөө аж ахуйн чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, залуу малчид, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийн гадаадын улс оронд туршлага судлах аялал хийхийг бодлогоор дэмжиж ажиллана.

Аюулгүй орчинг бүрдүүлэх талаар

1.5.1 Сумын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, хэв журмын зөрчил, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.

1.5.2 Архи, согтууруулах ундааны зохистой хэрэглээг сумандаа хэвшүүлэх бодлогын арга хэмжээ авч, "Архигүй амьдрал" хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.5.3 Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, урамшуулалтай малчдын бүлэг холбоод байгуулах шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан ажиллана.

ХОЁР: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Чанартай боловсрол, соёл урлагийн үйлчилгээ

2.1.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын ажлуудыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.1.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг халаалт, бохир, цэвэр усны нэгдсэн системд холбох, ариун цэврийн байгууламж байгуулах ажлыг шат дараатайгаар эхлүүлнэ.

2.1.3 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинг камержуулж, хүүхэд хамгаалал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.1.4 Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүрэлцээг нэмэгдүүлж, хүүхдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.

2.1.5 Иргэдэд мэргэжлийн урлагийн шилдэг бүтээл, соёл урлагийн чанартай үйлчилгээг хүргэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.

2.1.6 "Хүүхдийн авьяас билгийг нээн хөгжүүлэх, соёл, уламжлал ёс заншлыг өвлүүлэх, бүтээлч орчин бий болгох зорилгоор "Хүүхдийн номын ордон" байгуулна.

Гэр бүл, ахмад, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд хамгааллын бодлогын талаар

2.2.1 Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйлчилгээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Хүүхдийн хөгжлийн төв, Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийг сумандаа байгуулж, үйл ажиллагааг дэмжинэ.

2.2.2 Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, нийгмийн харилцаанд адил тэгш оролцох боломжоор хангана.

2.2.3 Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулж санаачлагч, зөвлөн туслагч, баялаг бүтээгч болгох "Ахмадаа ачлах" хөтөлбөр болон "Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.2.4 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулж, хөдөлмөр эрхлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтыг аялал жуулчлал, үйлчилгээний салбартай уялдуулан бодлогоор дэмжинэ.

ГУРАВ: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Төсөв санхүү, орон нутгийн өмчийн талаар

3.1.1 Төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж төсвийн байгууллагын албан хаагчид болон иргэд төсвөө хянах, төсвийн харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх зорилтыг хангана.

3.1.2 Орон нутгийн өмчийн эд хөрөнгө, нийтийн эзэмшлийн байгууламжийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажиллана.

3.1.3 Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хангана.

3.1.4 Тэтгэврийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж сайн дурын даатгалд хамруулна.

3.1.5 Мэргэжилтэй залуучууд, төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй ажил, мэргэжилд зуучлах, эзэмшсэн мэргэжлээрээ бизнес, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих, мөн оюутнуудад суралцах хугацаандаа ажил хөдөлмөр хийж туршлагажих, орлого олоход нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

Хөдөө аж ахуй, мал аж ахуйг хөгжүүлэх бодлогын талаар

3.2.1 Малын үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг зөв зохистой өсгөх, шинэ технологи нэвтрүүлнэ.

3.2.2 Малын тоо, сүргийн бүтцийн зохистой харьцааг баримталж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхтай малын тоог нэмэгдүүлэх бодлого баримтална.

3.2.3 Бэлчээрийн усан хангамжийг жил бүр нэмэгдүүлнэ.

3.2.4 Мал аж ахуйн салбарт мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэн, давтан сургах, орон нутагт ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

3.2.5 Мал эмнэлэг, малын эмчийн чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний гаралт, тархалтыг бууруулах, халдваргүйжүүлэх, дархлаажуулах ажлыг эрчимжүүлнэ.

3.2.6 Нийт бэлчээрийн тодорхой хувийг отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгон ажиллана.

Газар тариаланг хөгжүүлэх талаар

3.3.1 Газрын нөөц, боломжид тулгуурлан сумын атар болон атаршсан талбайг сэргээн тариалалт хийж, төмс, хүнсний ногоо, тэжээл, үр тарианы үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.3.2 Хүн амыг төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангах зорилт тавьж ажиллана.

3.3.3 Сумын төсөвт байгууллага, иргэдийг хүлэмжтэй болгох ажлыг дэмжинэ.

3.3.4 Төмс, хүнсний ногооны бага оврын зоорь агуулах барих, жимс, жимсгэний тариалалтыг буй болгох, таримлын үр үржүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлж, үр тариа, төмс хүнсний ногоо тариалах газрыг хуулийн хүрээнд давуу эрхээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.

3.3.5 Сумандаа үр тариа, хүнсний ногоо, малын тэжээл тариалах, үйлдвэрийн аргаар хорголжин, багсармал тэжээл бэлтгэх, төл, малын арьс элдэх, анхан шатны боловсруулалт хийх цех үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

Дэд бүтэц, харилцаа холбоог хөгжүүлэх талаар

3.4.1 Сумын төвийн цахилгаан хангамжийг сайжруулах, өргөтгөх, нэмэлт цахилгаан дамжуулах шугам барих, суурилагдсан хүчин чадлаас давсан толгой дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.4.2 Орчин үеийн мэдээлэл, харилцаа, холбооны дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл холбооны үйлчилгээг иргэн, байгууллага, аж ахуйн нэгж бүрт хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4.3 Сумын иргэдийн интернет, үүрэн холбоо, телевиз, радио үйлчилгээний хурд, багтаамжийг нэмэгдүүлнэ.

3.4.4 Сумын хаягжилтын системүүдийн хоорондын уялдааг сайжруулж, шуудан, илгээмжийн үйлчилгээг шуурхай, хялбар хүргэх бодлого хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

4.1.1 Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтэд зарцуулах барьцаа хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, нөхөн сэргээлтийн ажлын хяналтыг сайжруулж, уул уурхайн дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлнэ.

4.1.2 Байгаль орчныг хамгаалах, иргэдийн эрх ашиг, орон нутгийн тогтвортой хөгжил, хариуцлагатай уул уурхайг дэмжих, ашиглалт ба хариуцлагын хамтран ажиллах гэрээг бүх аж ахуйн нэгжүүдтэй байгуулж ажиллана.

4.1.3 Мод тарих хөдөлгөөнийг байнгын, өрсөлдөөнт, сайн дурын хэлбэрээр өрнүүлэх байдлаар сумын төв, замын дагуух ногоон байгууламжийг нэмэгдүүлж, бичил цэцэрлэгүүдийг байгуулж орчны тоосжилт, агаарын хуурайшилтыг бууруулна.

4.1.4 Сумын төвийн хог хаягдал булах төвлөрсөн цэгийг хот орчны бохирдол үүсэхгүй байхаар тохижуулж, мод тарьж, хашаажуулна.

4.1.5 Матад сумын аялал жуулчлалын салбарын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан, олон улсын болон бүс нутгийн жишиг түвшинд хөгжүүлж, аялал жуулчлалын салбараас иргэд, аж ахуйн нэгжийн олох орлогыг нэмэгдүүлнэ.

4.1.6 Аялал жуулчлалыг хөгжүүлэх, үйлчилгээг сайжруулах, түүх, соёлын онцлогийг харуулсан бэлэг дурсгалын зүйлс үйлдвэрлэгчдийг бодлогоор дэмжиж, аялал жуулчлалаас төсөвт орох орлогыг нэмэгдүүлнэ.

ТАВ: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:

5.1.1 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллана.

5.1.2 Сумын төвийн зам засвар арчлалтыг нэмэгдүүлнэ.

5.1.3 Сумын нутгийн захиргааны ордны барилга барина.

5.1.4 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг газрын тосны нийгмийн хариуцлагын гэрээгээр барьж ашиглалтанд оруулна.

5.1.5 Сумын төвийг цэвэр, бохир ус, дулааны нэгдсэн сүлжээнд холбоно.

5.1.6 Сумын наадмын талбайн тохижилт, засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.

5.1.7 Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийг шийдвэрлэнэ.

5.1.8 Ерөнхий боловсролын сургуулийн Спорт заалны дээврийн засварыг хийж гүйцэтгэнэ.

5.1.9 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.